



## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2019 оны 4 сарын 10 өдөр

Дугаар 49

Улаанбаатар хот

Г Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, Г  
хувьцаа эзэмшигчдийн бүтцэд өөрчлөлт оруулахыг  
зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.1, 63.1.2, Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 04 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 6.12 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Сикап ҮЦК” ХХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг 1,315,825,000 /нэг тэрбум гурван зуун арван таван сая найман зуун хорин таван мянга/ төгрөгөөр нэмэгдүүлж, хавсралтад заасны дагуу хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтцэд өөрчлөлт оруулахыг зөвшөөрсүгэй.

2. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтцэд оруулсан өөрчлөлтийг тусгай зөвшөөрлийн болон улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглүүлж, компанийн шинэчилсэн дүрмийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлж, холбогдох баримт бичгийг ажлын 15 хоногийн дотор Санхүүгийн зохицуулах хороонд ирүүлэхийг “Сикап ҮЦК” ХХК /Ч.Тэмүдэр/-д үүрэг болгосугай.


3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Б.Ариунаа/-нд даалгасугай.

ДАРГА



С.ДАВААСҮРЭН

Санхүүгийн зохицуулах хорооны  
2019 оны 4 дүгээр сарын 09-ны өдрийн  
49 дүгээр тогтоолын хавсралт



“Сикап ҮЦК” ХХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийн  
хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтцэд оруулсан өөрчлөлт

№	Хувьцаа эзэмшигчийн нэр	Хувьцааны нэрлэсэн үнэ /₮/	Хувьцааны эхний үлдэгдэл			Өөрчлөлт		Хувьцааны эцсийн үлдэгдэл		
			Тоо ширхэг	Үнийн дүн /₮/	Эзлэх хувь /%/	Хувьцааны тоо	Үнийн дүн /₮/	Тоо ширхэг	Үнийн дүн /₮/	Эзлэх хувь /%/
1	Д.Маралхүү	1,000	7,500	7,500,000	2.4	-	-	7,500	7,500,000	0.45
2	П.Чинзориг	1,000	7,500	7,500,000	2.4	-	-	7,500	7,500,000	0.45
3	Ч.Бадмаараг	1,000	173,750	173,750,000	56.0	-	-	173,750	173,750,000	10.7
4	Ито Наоко	1,000	61,250	61,250,000	19.8	-	-	61,250	61,250,000	3.8
5	С.Лхагвасүрэн	1,000	60,000	60,000,000	19.4	-	-	60,000	60,000,000	3.8
6	“Мачи окоши Монгол энерги” ХХК	-	-	-	-	1,315,825	1,315,825,000	1,3515,825	1,315,825,000	80.8
	Нийт	1,000	310,000	310,000,000	100	1,315,825	1,315,825,000	1,625,825	1,625,825,000	100